



## ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Баримт бичгийн үйлчлэх хугацаа: 2021 - 2024 он /4 жил/

Төлөвлөгөөг баталсан:

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА



Төсвийн ерөнхийлөн захирагч

/Ц.МӨНХБАТ/

2021.04.26

Төлөвлөгөөг боловсруулсан:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН  
ДАРГА



Төсвийн Шууд захирагч

/Ж.ГАНТУЛГА/

2021.04.26

**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА**

1. Нийтлэг үндэслэл
2. Мандатын шинжилгээ
3. Алсын хараа
4. Эрхэм зорилго
5. Орчны шинжилгээ
6. Стратегийн зорилго
7. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги
8. Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал
9. Хавсралт

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### Оршил

Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.3-т “Яамны харьяа агентлаг нь байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулан салбарын сайдаар, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг аймаг, нийслэлийн Засаг даргаар тус тус батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулна.” гэж заасны дагуу аймгийн “Орон нутгийн өмчийн газар”-ын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг Монгол Улсын хуулиуд, Улсын Их Хурал, Засгийн газрын бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд боловсрууллаа.

### Үндэслэл

Стратеги төлөвлөгөөг нь дараах баримт бичгүүдийг үндэслэн боловсруулав. Үүнд:

- Монгол улсын үндсэн хууль
- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
- Иргэний хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Орон сууц хувьчлах тухай хууль
- Компанийн тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 26 дугаар тогтоол
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал
- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

- Аймгийн 2021-2024 хүртэлх “Стратеги төлөвлөгөө”

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

## Мандатын шинжилгээ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		13
үүнээс	Тухайн салбарын хуулийн тоо	7
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	7
Ерөнхий чиг үүрэг-1: Худалдан авах ажиллагаа		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх	1.1.1. Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг, батлуулах, цахим системд нийтлэх	Аймгийн Засаг даргын тамгын газар, ХОХБТХэлтэс
	1.1.2 Орон нутагт худалдан авах ажиллагааг зохион байгуулах	Сумдын засаг дарга, орлогч дарга
	1.1.3 Худалдан авах ажиллагааг тайлагнах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, саналаа холбогдох байгууллагад хүргүүлэх	Аймгийн Засаг даргын харьяа агентлагууд
	1.1.14 Худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйгээр хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, хяналт тавих	Орон нутгийн төрийн байгууллагууд
Ерөнхий чиг үүрэг-2: Орон нутгийн өмчийн удирдлага		
ҮЧҮ-1: Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлийг хянах	1.1.1. Орон нутгийн өмчийн талаар бодлого, чиглэл, дүрэм журам, баримт бичгийн төсөл боловсруулах	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Аймгийн ИТХ, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд
	1.1.2. Засгийн газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас хувьчилсан орон сууцны хувьчлах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг тайлагнах	
	1.1.3 Орон нутгийн өмчийн эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулах	
	1.1.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмчийн харилцааг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлүүлэх	
	1.1.5 Орон нутгийн өмчийн ашиглалтгүй, илүүдэлтэй хөрөнгийг түрээслэх, дуудлагаар худалдах ажиллагааг зохион байгуулах	

	1.1.6. Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, гадаад, дотоодын зээл, тусламж, хандиваар бий болсон үндсэн хөрөнгийг орон нутгийн өмчийн бүртгэлд авах	
	1.1.7. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, удирдлага, зохицуулалтаар хангах	
	1.1.8. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, өмч хамгаалах зөвлөлийг мэргэжил арга зүй, зөвлөмжөөр хангах	

**ГУРАВ. АЛСЫН ХАРАА**

Худалдан авах ажиллагаанд цахим тендерийн тоог нэмэгдүүлж, тендер шалгаруулалтын үнэлгээнд дэвшилтэт арга технологи нэвтэрсэн даруй орон нутагт ашиглаж, төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо сайжруулах хүний оролцоог багасгах, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан бодлогыг дэмжин ажиллах

Орон нутгийн өмчийн талаар бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах, өмчийн нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэлээр хяналт тавих, өмчийн улсын үзлэг тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, удирдлага зохицуулалтаар хангах

**ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО**

Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг зөв зохистой төлөвлөж, нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэхийн сацуу Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлийг хянах.

**ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ**

<b>Орчны шинжилгээ</b>	
<b>Дотоод орчин</b>	
<p><b><u>Давуу тал</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Албан хаагчдын 50 хувь нь байгууллагадаа тогтвортой ажиллаж, албан ажилдаа мэргэшсэн</li> <li>- Байгууллагын тоног төхөөрөмжийн хүчин чадал дундаас дээш үзүүлэлтэй</li> <li>- Хүний нөөцийн хувьд ажиллах хүчний дундаж нас залуу тул өөрчлөлт, шинэчлэлтийг хүлээн авах чадвар сайн</li> <li>- Тендер шалгаруулалтад орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр оролцох боломжтой.</li> </ul>	<p><b><u>Сул тал</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжилтнүүдийн тогтвор суурьшил муу.</li> <li>- Албан хаагчдын хэрэгцээнд суурилсан сургалт хангалтгүй</li> <li>- Төрийн албаны тухай хууль, байгууллагын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт дутмаг.</li> <li>- Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байх зарчмыг хэрэгжүүлэх, албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг үе шаттайгаар дээшлүүлэхэд зориулсан зардлын эх үүсвэр дутагдалтай.</li> <li>- Албан хаагчдын ажил үйлчилгээ явуулах албан өрөө тасалгааны зай хэмжээ стандартад хүрдэггүй</li> </ul>
<b>Гадаад орчин</b>	
<p><b><u>Боломж</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Худалдан авах ажиллагаатай холбоотой төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг олон нийтэд ил тод болгосон тул иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагын хяналт</li> </ul>	<p><b><u>Эрсдэл</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Тус газраас зохион байгуулах, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг, төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар зэрэг шаардлагатай материалыг</li> </ul>

сайжирсан.	захиалагчаас цаг хугацаанд нь ирүүлдэггүй. - Орон нутгийн өмчийн газрын эрх, үүргийн талаар эрх зүйн нарийвчилсан зохицуулалт дутмаг
------------	---

### **ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО**

Худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулах, тайлагнах, худалдан авах ажиллагааны тогтолцоонд техник технологи, тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд хүний оролцоог багасгасан үйл ажиллагаа дэмжин ажиллах, Орон нутгийн өмчийн талаар бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах, өмчийн нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэлээр хяналт тавих

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН  
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүгэц	№	Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Төлөвлөсөн онд хүрэх түвшин			Зорилтот оны түвшин /2024/	Санхүүгийн эх үүсвэр, хэмжээ	Хариуцах байгууллага
						2021	2022	2023			
<b>Ерөнхий чиг үүргийн нэр: 1. Орон нутгийн өмчийн удирдлага</b>											
<b>Үндсэн чиг үүргийн нэр: 1 Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийг удирдлагаар хангах, өмчийн бодлого, шийдвэр хэрэгжүүлэх</b>											
Зорилт	1	Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулна.	Хөрөнгийн ашиглалт	Хувь	70	75	80	85	90	ОНТ 8.2	
	1	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд бүртгэлээр хяналт тавих	Тухайн жилд хамрагдсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тоо	тоо	142	40	142	113	29	ОНТ 8.2	
Арга	2	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй байгаа хөрөнгийг эдийн засгийн	Орлого төвлөрүүлэх хувь	Хувь	80	85	90	95	95	-	

**Орон нутгийн өмчийн газрын стратеги төлөвлөгөө  
2021-2024 он**

хэмжээ	эргэлтэд оруулан ашиглалтыг сайжруулах																			
	3	Улсын болон орон нутгийн төсөв, гадаад дотоодын зээл, тусламж хандив болон бусад эх үүсвэрээр хийгдсэн үндсэн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэх	Үндсэн хөрөнгийг бүртгэсэн хувь	Хувь	85	90	93	95	100	3										

**Ерөнхий чиг үүргийн нэр: 2. Худалдан авах ажиллагаа**

**Үндсэн чиг үүргийн нэр: 1. Орон нутгийн хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах**

Зорилт	3	Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч орон нутгийн аж ахуйн нэгжийн эзлэх хувь 2020 онд 30 байсныг 2024 онд 40 хувьд хүргэнэ	Орон нутгийн ААН-ийн эзлэх хувь	хувь	30	32	34	36	40	Үйл ажиллагаа
					15	18	20	25	30	Үйл ажиллагаа
Арга хэмжээ	1	Орон нутаг бүртгэлтэй аж ахуйн нэгжид чадавхжуулах сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан аж ахуй нэгжийн тоо	тоо	15	18	20	25	30	Үйл ажиллагаа

Орон нутгийн өмчийн газрын стратеги төлөвлөгөө  
2021-2024 он

Арга хэмжээ	2	Зарлагдсан тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймгийн вэбсайт болон пейж хуудсаар тухай бүр мэдээлэх	Нийт зарлагдсан тендерээс вэбсайт болон пейж хуудсанд урилга, үр дүнг нийтэлсэн тендерийн эзлэх хувь	70	80	85	90	100	Үйл ажиллагаа
Зорилт	4	Тухайн жилд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлуулах,							
Арга хэмжээ	1	Тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт батлуулах, төлөвлөгөөг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагад хүргүүлэх, худалдан авах ажиллагааны цахим системд нийтлэх	Жагсаалт батлагдаж, хүргүүлсэн хугацаа; нийтэлсэн байдал	Тоо	2	2	2	2	Үйл ажиллагаа
Зорилт	5	Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагад хүргүүлэн батлуулж, нийтэлсэн.							
Арга Хэмжээ	1	Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах	Төсөл, арга хэмжээний		55 төс	60 төсө	65 төсөл арга	Төсөл, арга	Үйл ажиллагаа
					2020 онд 4,5 тэрбум				

**Орон нутгийн өмчийн газрын стратеги төлөвлөгөө  
2021-2024 он**

э		хэрэгжилтийн тоо; хувь, хэмнэлт	тоо	<p>төгрөгийн арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 262,4 сая төгрөгийн хэмнэлт гарсан.</p>	<p>өл арга хэмжээ нээс 300 сая 280 сая төгрөгийн хэмнэлт</p>	<p>л арга хэмжээ эс 300 сая төгрөгийн хэмнэлт</p>	<p>хэмжээний хэрэгжлтийн тоо – 65%, хувь – 100%, хэмнэлт – 360 сая төгрөг өс</p>	
---	--	------------------------------------	-----	---	--	---	--	--